



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/50

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2016 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 234 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Хөтөлбөр батлах тухай" 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүмүүнлэгийн чиглэлээрх төрийн зарим чиг үүргийг аймгийн Улаан загалмай хороогоор гүйцэтгүүлэхэд 15,000,000 (арван таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Аймгийн Засаг даргаас аймгийн Улаан загалмайн хороотой 2021 онд хамтран ажиллах гэрээг байгуулан, хэрэжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Дээрх 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 03/07 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтын төр, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100112